



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 4/26

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г


Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, МУИС-ийн дүрмийн 4.5.8.3 дахь хэсэг, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлын 2015 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэр, МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 1.8, 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Их Сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох тухай нийтлэг журам"-ыг хавсралтаар баталж, 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. "Монгол Улсын Их Сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох тухай нийтлэг журам" батлагдсантай холбогдуулан Сургалтын нэгдсэн алба /М.Ундрам/-д бүрэлдэхүүн болон салбар сургуулийн Сургалтын албадад мэдээлэл хүргүүлэхийг үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалт эрхэлсэн дэд захирал /О.Мөнхбат/, Төгсөлтийн дараах сургуулийн захирал /Б.Отгонтөгс/, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлууд, сургалтын албаны эрхлэгч нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

My document Tushaal 2015 May

20150506

## **МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДАД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Монгол Улсын Их Сургуульд (цаашид МУИС гэх) суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний суралцагчдын сурч боловсрох, судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй суралцагчийг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих зорилгоор тэтгэлэг олгох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Энэхүү журмаар МУИС-д амжилттай суралцаж буй шилдэг суралцагчид болон улс, олон улсын олимпиадад амжилттай оролцож тус сургуульд элссэн элсэгчдэд олгох МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, эрдэм шинжилгээний ажил амжилттай хийж онцгой үр дүн гаргасан суралцагчид олгох Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг, докторын сургалтанд суралцаж буй МУИС-ийн залуу багшид олгох тэтгэлэг болон гадаад дотоодын байгууллага, хувь хүний нэрэмжит тэтгэлгийг олгох үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3. Тэтгэлгийн зорилго, төрөл, олгох байгууллага, санхүүжилтийн эх үүсвэр, олгох хугацаа, оюутанд тавигдах шаардлага, нөхцөл зэргээс хамааруулан бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг тухайн байгууллагаас гаргасан тэтгэлэг олгоход баримтлах журам, МУИС-тай байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу зохион байгуулна.
- 1.4. Энэхүү журам нь хоёр дахь дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа болон бакалаврын хөтөлбөрт эчнээ, орой хэлбэрээр суралцаж буй суралцагчид, гадаад улсаас МУИС-д суралцаж буй оюутан, түр сургалтанд хамрагдаж буй суралцагчдад хамаарахгүй.

### **Хоёр. Тэтгэлэгийн төрлүүд, олгох хэлбэр**

- 2.1. Тэтгэлэг нь МУИС-д амжилттай суралцаж буй авъяаслаг, шилдэг оюутанд дэмжлэг үзүүлэхэд зориулагдах ба суралцагчийн сургалтын төлбөр болон амжиргааны зардлыг бүхэлд нь юмуу тодорхой хэсгийг мөнгөн болон бусад хэлбэрээр (сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тодорхой багц цагийн төлбөрөөс чөлөөлөх г.м.) санхүүжүүлэхэд буцалтгүй тусламж хэлбэрээр олгогдоно.
- 2.2. Суралцагчийг гадаад, дотоодын байгууллагын болон хувь хүний нэрэмжит тэтгэлгээр МУИС-д суралцуулах, гадаадын их дээд сургуульд сургууль хоорондын гэрээгээр болон оюутан солилцооны хөтөлбөрт хамруулан суралцуулах зэрэг нь тэтгэлэгийн төрөлд хамаарна.
- 2.3. Оюутан суралцагчдад олгох тэтгэлэг нь дараах төрлүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай Монгол улсын хуулийн дагуу суралцагчдад олгох үндэсний ба урамшууллын тэтгэлэг
  - МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
  - МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг
  - Докторын сургалтанд суралцаж буй МУИС-ийн багшид олгох тэтгэлэг
  - Гадаад, дотоодын байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг
  - Төгсөгчид, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлэг
  - Бусад тэтгэлэг
- 2.4. МУИС-иас олгох тэтгэлгийн нөхцөл, оюутанд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, шалгаруулах, тэтгэлгийг олгох г.м. үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулах ба бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг олгоход тавигдах шаардлага, болзол зэргийг харгалзан оюутан суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлэх, улмаар анхан шатны шалгаруулалт явуулах ажлыг МУИС хариуцан зохион байгуулна.
- 2.5. Тэтгэлэгийн мөнгөн дүнгийн хэмжээ, олгох хугацаа, давтамж, тэтгэлэгт хамрагдах хүний тоо зэрэг нь тэтгэлгийн төрлөөс хамаарч харилцан адилгүй байна.
- 2.6. Ижил төрлийн тэтгэлэгийг нэг суралцагчид давхардуулж олгохгүй.

### **Гурав. Тэтгэлгийн талаархи мэдээлэл**

- 3.1. Тэтгэлгийн талаархи мэдээллийг Сургалтын нэгдсэн алба, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба хариуцан, тэтгэлэгт нэр дэвшигчийн бүрдүүлбэл зохих материалыг хүлээж авах хугацаанаас 10-аас доошгүй хоногийн өмнө оюутан суралцагчдад зарлан мэдээлж, холбогдох мэдээллийг МУИС-ийн цахим хуудсанд байрлуулна.
- 3.2. Тэтгэлэгт хамрагдах оюутны хүсэлт, өргөдөл, анкет, сурлагын дүнгийн болон хувийн мэдээлэл г.м. тухайн тэтгэлгийг олгоход шаардагдах бичиг баримтыг Сургалтын нэгдсэн алба, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба хүлээн авч, материалын бүрдэлт болон тухайн тэтгэлгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг нягтлан, дараагийн шатны шалгаруулалтанд бэлтгэнэ.
- 3.3. Тэтгэлэг олгосон талаархи мэдээллийг Сургалтын нэгдсэн алба, Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба нэгтгэн мэдээллийн сан үүсгэн байнга шинэчилж, МУИС-ийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр нийтэд мэдээлнэ.
- 3.4. Тэтгэлэгтэй холбогдолтой мэдээллийн нэгдсэн санг сургалтын СиСи мэдээллийн системтэй холбон тогтмол шинэчлэх асуудлыг Мэдээллийн технологийн алба Сургалтын нэгдсэн албатай хамтран зохион байгуулж, жил бүр МУИС-ийн хичээлийн жилийн тайланд тусгана.

### **Дөрөв. Суралцагчдад тавигдах нийтлэг шаардлага**

- 4.1. Тэтгэлгийн шалгаруулалтанд нэр дэвших суралцагч нь дараах нийтлэг шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- Улсын болон олон улсын олимпиадад оролцож амжилт гарган тухайн чиглэлээр МУИС-д элссэн элсэгч байх

- Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр МУИС-д элсэгчдийн авбал зохих оноог авч элссэн байх
- Улиралд дунджаар 12-оос доошгүй багц цагийн хичээл сонгон хоёроос доошгүй улирал амжилттай судалж, суралцах чадвар, идэвхи санаачилгаа илтгэн харуулсан бакалаврын хөтөлбөрийн суралцагч байх
- Хоёроос доошгүй улирал тасралтгүй суралцаж, улиралд дунджаар 6-аас доошгүй багц цагийн хичээл амжилттай судалсан магистрант, докторант байх
- Монгол улсын Засгийн газраас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгож буй үндэсний болон урамшууллын тэтгэлэгт хамрагдах болзлыг хангасан байх
- Олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдсон эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн наадам, уралдаан тэмцээн, сайн дурын арга хэмжээнд амжилттай оролцож шалгарсан байх
- Докторын сургалтанд гурваас доошгүй улирал тасралтгүй идэвхитэй суралцсан МУИС-ийн үндсэн орон тооны багш байх
- Өмнө нь МУИС-ийн дүрэм, журмыг зөрчиж ямар нэгэн сахилгын шийтгэл, сануулга авч байгаагүй байх
- Энэхүү нийтлэг шаардлагыг хангаагүйгээс тэтгэлэгт хамрагдах боломжгүй суралцагч дараагийн хичээлийн жилд шаардлага хангасан тохиолдолд тэтгэлэгт өрсөлдөх боломжтой.

4.2. Эдгээр нийтлэг шаардлага нь МУИС-иас олгох тэтгэлгийн төрлүүдэд хамаарах ба тэтгэлэгт нэр дэвшигч дээрх шаардлагуудыг холбогдох чиглэлээр хэсэгчлэн биелүүлсэн байж болно. Бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг олгоход нэмэлт болзол, шаардлагыг тавьж болно.

### **Тав. Тэтгэлэгийн хүсэлт, материал хүлээн авах**

- 5.1. Энэ журмын 4-р бүлэгт заасан нийтлэг шаардлага болон тухайн тэтгэлэгт тавигдах бусад нөхцөл, шаардлагыг хангасан суралцагч бүрдүүлбэл зохих материалыг бүрдүүлэн зарлагдсан хугацаанд бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- 5.2. Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба материалын бүрдүүлэлт, тэтгэлгийн нөхцөл, болзлыг хангасан байдал зэргийг нягтлан шалгаж, шаардлага хангасан материалыг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж Сургалтын нэгдсэн албанд хүргүүлнэ.
- 5.3. Тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргаж буй суралцагч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
  - Тэтгэлэгт хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн суралцагчийн хувийн өргөдөл
  - Суралцагчийн талаархи мэдээллийг агуулсан тэтгэлгийн анкет
  - Иргэний болон оюутны үнэмлэхийн хуулбар
  - Сурлагын дүнгийн дэлгэрэнгүй тодорхойлолт
  - Суралцагчийн хувийн амжилтыг илэрхийлэх баримт бичиг, түүний хуулбар
  - Профессор багшийн тодорхойлолт (шаардлагатай нөхцөлд)
  - Тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн тодорхойлолт (шаардлагатай нөхцөлд)

- Тэтгэлэгт хамрагдахтай холбогдуулж бичсэн эссэ (шаардлагатай нөхцөлд)
  - Бусад (тэтгэлгийн төрөл, нөхцлөөс хамаарч бүрдүүлэх нэмэлт материал)
- 5.4. Хугацаа хожимдуулсан болон баримт бичгийн бүрдүүлэлт дутуу материалыг хүлээж авахгүй.

### **Зургаа. Суралцагчдыг шалгаруулах**

- 6.1. Тэтгэлэгт хамрагдах суралцагчийг шалгаруулах, тэтгэлэг олгох гадны байгууллагад анхан шатны шалгаруулалтыг хийж холбогдох материалыг хүргүүлэх асуудлыг Сургалтын нэгдсэн алба хариуцан зохион байгуулна.
- 6.2. Сургалтын нэгдсэн албанаас шалгаруулалт явуулах ажлын хэсгийг томилж ажиллуулна.
- 6.3. Ажлын хэсэг оюутан суралцагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх, тэдний эрдэм шинжилгээний ажил хийж авъяас чадварыг хөгжүүлэх, шударга өрсөлдөөнийг дэмжих, урамшуулах зарчмыг баримтлан ажиллана.
- 6.4. Ажлын хэсэг шалгаруулалт явуулахдаа нэр дэвшигчдийн сурлага, эрдэм шинжилгээ, урлаг спортын амжилтын үзүүлэлтүүд, түүнчлэн тухайн тэтгэлэгт тавигдах бусад болзол шаардлагыг хэрхэн хангасан байдлыг гол шалгуур үзүүлэлт болгоно.
- 6.5. Шаардлагатай нөхцөлд тэтгэлэгт нэр дэвшигчтэй ярилцлага хийнэ.
- 6.6. Шалгаруулалтын дүнг ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан, хурлын тэмдэглэлийн хамт Сургалтын нэгдсэн албанд хүлээлгэж өгнө.
- 6.7. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сургалтын нэгдсэн алба, багш нарын төлөөллөөс бүрдсэн байна. Шаардлагатай нөхцөлд оюутны болон төгсөгчдийн, санхүүжүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн төлөөллөөс ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцуулж болно.
- 6.8. МУИС-аас өөр байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийн хувьд анхан шатны шалгаруулалт явуулж нэр дэвшүүлсэн суралцагчдын эцсийн шатны шалгаруулалтыг тэтгэлэг олгогч байгууллага, хувь хүн хийж сонгогдсон оюутнуудын талаархи мэдээллийг Сургалтын нэгдсэн албанд ирүүлнэ.

### **Долоо. Тэтгэлэг олгох, батламжийг гардуулах**

- 7.1. Тэтгэлэгт хамрагдах болзол хангаж шалгарсан суралцагчдад Сургалтын нэгдсэн алба шалгаруулалтын дүнг мэдээлж, уг мэдээллийг МУИС-ийн вэб хуудсанд байрлуулна.
- 7.2. МУИС-иас олгох тэтгэлгийн батламжийг хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагаа, Эрдмийн зөвлөлийн хуралдаан болон бусад арга хэмжээний үеэр гардуулна.
- 7.3. Бусад байгууллага, хувь хүмүүсийн нэрэмжит тэтгэлгийг гардуулах ёслолын ажиллагааг тухайн байгууллага, хувь хүмүүстэй байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу дангаар, эсвэл хамтран зохион байгуулна.
- 7.4. Оюутанд тэтгэлэг олгох тухай захирлын тушаалыг үндэслэн Санхүү, эдийн засгийн хэлтэс тэтгэлэгийн санхүүжилтийг ажлын 5 хоногт багтаан холбогдох тооцоог хийнэ.
- 7.5. Тэтгэлэг олгох хугацааг тухайн улиралд оюутны судлахаар сонгосон хичээлээ баталгаажуулахад саад болохгүйгээр зохицуулна.

### **Найм. Тэтгэлгийн санхүүжилтийн эх үүсвэр**

- 8.1. Оюутан суралцагчдад олгох тэтгэлгийн санхүүжилтийн эх үүсвэр нь нээлттэй, тодорхой байх, улс төр, шашны үйл ажиллагааг сурталчлахад чиглэгдээгүй байх шаардлагатай.
- 8.2. Тэтгэлгийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
  - Улсын төсвийн эх үүсвэр
  - МУИС-ийн төсөвт тусгагдсан эх үүсвэр
  - Гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж
  - Бусад эх үүсвэр
- 8.3. Тэтгэлэг олгогч байгууллага нь тэтгэлгийн санхүүжилтийг суралцагчид шууд гардуулах, эсвэл МУИС-иар уламжлан олгож болно.
- 8.4. Тэтгэлэгийн санхүүжилтийн хэлбэрээс шалтгаалан МУИС-иар уламжлан тэтгэлгийг олгох тохиолдолд шийдвэрийг МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 8.5. Тэтгэлгээс суутгал тооцохгүй бөгөөд гадаад валютаар санхүүжилт хийгдсэн тохиолдолд тухайн өдрийн Монгол банкны валютын ханшаар хөрвүүлэн төгрөгөөр холбогдох тооцоог хийнэ.

### **Ес. Тэтгэлгийг түдгэлзүүлэх, цуцлах**

- 9.1. Оюутан улирлын болон жилийн чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг олголтыг түр хугацаагаар түдгэлзүүлэх ба үргэлжлүүлэн суралцах үед тэтгэлгийг олгоно.
- 9.2. Тэтгэлэгт хамрагдсан боловч захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, бусад шалтгаанаар сургуулиас түр чөлөөлөгдсөн, сурлагын амжилт нь эрс буурсан (голч дүн 2.8-аас доош болсон), тэтгэлэгт хамрагдахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн г.м. шалтгаанаар тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох боломжгүй нь тогтоогдсон нөхцөлд тэтгэлэг олголтыг бүрмөсөн цуцална.

\*\*\*\*\*

## **МУИС-ИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ**

### **Нэг. Тэтгэлгийн зориулалт**

- 1.1. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг нь тус их сургуульд суралцаж буй бакалаврын түвшний суралцагчдын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй шилдэг оюутныг урамшуулах, зарим мэргэжлээр элсэгчдийг дэмжих зорилготой.
- 1.2. Тэтгэлгийг хоёр дахь дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа болон эчнээ, орой хэлбэрээр суралцаж буй, түүнчлэн гадаад орнуудаас МУИС-д суралцаж буй оюутан, түр сургалтанд хамрагдаж буй суралцагчид олгохгүй.
- 1.3. Тэтгэлэгт хамрагдсан оюутан хос болон давхар мэргэжлээр суралцах тохиолдолд зөвхөн суурь мэргэжлээр суралцахад нь зориулан тэтгэлэг олгоно.

### **Хоёр. Тэтгэлэгт нэр дэвшүүлэх, шалгаруулах**

- 2.1. Дараах болзлын аль нэгийг хангасан суралцагч МУИС-ийн нэрэмжит тэтгэлэгт нэр дэвших боломжтой. Үүнд:
  - Тухайн хичээлийн жилд математик, физик, хими, биологи, газарзүй, мэдээлэл зүй, монгол хэл, гадаад хэл, түүх, нийгмийн ухааны чиглэлээр зохион байгуулагддаг, БСШУЯ-ны сайдын тушаалаар баталсан улсын олимпиадад эхний 3 байрт шалгарч МУИС-д элссэн оюутан
  - Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр 700 болон түүнээс дээш оноо авч МУИС-д байгаль, нийгэм, хүмүүнлэг, инженерчлэлийн мэргэжлийн чиглэлээр элссэн оюутан (байгалийн ухааны чиглэлээр элсэгчдийн хувьд ЭЕШ-ын үнэлгээ 650-аас доошгүй байх)
  - Олон улсын олимпиадад шагналт байр эзэлж медаль хүртсэн оюутан
  - Гурваас доошгүй улирал дараалан 3.2-оос доошгүй голч үнэлгээтэй суралцсан оюутан (байгалийн ухаан, инженерчлэлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутны хувьд сурлагын голч дүн 3.0-аас доошгүй байх)
  - Суралцаж буй чиглэлээрээ их дээд сургуулиудын оюутны дунд зохион байгуулагддаг мэргэжлийн олимпиадад эхний 3 байр эзэлсэн оюутан
  - Улсын болон олон улсын чанартай урлаг, спортын наадам, уралдаан тэмцээнд МУИС-ийг төлөөлөн оролцож эхний 3 байр эзэлсэн оюутан.
- 2.2. Тэтгэлэгт мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба нэр дэвшүүлэх ба оюутан өөрийгөө дэвшүүлэн өрсөлдөх боломжтой.
- 2.3. Тэтгэлэгт нэр дэвшигчдийг энэ журмын 6-р бүлэгт заасны дагуу сонгон шалгаруулна.

### **Гурав. Тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох**

- 3.1. Тэтгэлгийн батламжийг хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагаан дээр суралцагчдад МУИС-ийн захирал гардуулна.

- 3.2. Тэтгэлгийг жилд нэг удаа, нэг суралцагчид давхардуулахгүйгээр олгоно.
- 3.3. Тэтгэлэг олгох нийт хугацаа 2.5 жилээс хэтрэхгүй байна.
- 3.4. Улсын олимпиадад эзэлсэн байрыг нь харгалзан МУИС-д шинээр элсэгчид нэг удаагийн тэтгэлгийг хичээлийн жилээр юмуу улирлаар тооцож дараах харьцаагаар олгоно. Үүнд:
- I байр: сургалтын төлбөрийн 100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг
  - II байр: сургалтын төлбөрийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг
  - III байр: сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэлэг
- 3.5. Олон улсын олимпиадад шагналт байр эзэлж, медаль хүртсэн оюутанд улсын олимпиадын 1-р байранд шалгарсан оюутныхтай ижил хэмжээний тэтгэлэг олгоно.
- 3.6. Хичээлийн жилийн нэг улиралд суралцагчид олгох тэтгэлгийн мөнгөн дүнгийн хэмжээ тухайн хөтөлбөрийн 15 багц цагийн сургалтын төлбөрөөс илүүгүй байна.
- 3.7. Нэг хичээлийн жилд 30 хүртэл суралцагчид тэтгэлэг олгоно. МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг хүртсэн тухай тэмдэглэгээг тухайн төгсөгчийн мэргэжлийн диплом дээр хийж болно.

#### **4. Тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох оюутанд тавих шаардлага**

- 4.1. Тэтгэлэгт хамрагдсан оюутанд МУИС-ийн нэрэмжит тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох тохиолдолд дараах шаардлагыг тавина. Үүнд:
- Улиралд 12-оос доошгүй багц цагийн хичээл сонгон судалсан байх
  - Сурлагын голч дүн тэтгэлэг олгож эхлэх үеийнхээс буураагүй байх
  - Сургалтын төлбөрийн болон дүнгийн өргүй байх
  - Сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаагүй байх
- 4.3. Тэтгэлгийг үргэлжлүүлэн олгох оюутны сурлагын голч дүнгийн мэдээлэл болон холбогдох бусад материалыг Сургалтын нэгдсэн алба, бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба нягтлан хянаж, баталгаажуулна.

\*\*\*\*\*



## МУИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

### Нэг. Тэтгэлгийн зориулалт

- 1.1. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг нь тус их сургуульд суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний суралцагчдын судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах зорилготой.
- 1.2. Тэтгэлгийг судалгаа шинжилгээний ажилд идэвхитэй оролцож, профессор багшийн хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрт оролцон судалгааны туслхаар ажилласан, эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож онцгой амжилт гаргасан, эрдэм шинжилгээний шинэлэг үр дүн бүхий өгүүлэл бичиж хэвлүүлсэн, судалгааны шинжилгээний ажил хийж гүйцэтгэх онцгой авъяастайгаа харуулсан шилдэг суралцагчид олгоно.

### Хоёр. Тэтгэлэгт нэр дэвшүүлэх, шалгаруулах

- 2.1. Дараах болзлын аль нэгийг хангасан суралцагч МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэгт нэр дэвших боломжтой. Үүнд:
  - Улсын болон олон улсын чанартай оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож эхний 3 байрт шалгарсан суралцагч
  - Судалгааныхаа ажлын үр дүнгээр шинэлэг үр дүн бүхий эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн суралцагч
  - Шинэ технологи, бүтээгдэхүүн, загвар боловсруулсан суралцагч
- 2.2. Тэтгэлэгт тухайн суралцагчийн судалгааны ажлын удирдагч профессор багш, мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургууль нэр дэвшүүлэн өрсөлдүүлэх боломжтой.
- 2.3. Тэтгэлэгт нэр дэвшигчдийг энэ журмын 6-р бүлэгт заасны дагуу сонгон шалгаруулна.
- 2.4. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг хүртсэн тухай тэмдэглэгээг тухайн төгсөгчийн мэргэжлийн диплом дээр хийж болно.

### Гурав. Тэтгэлгийн хэмжээ

- 3.8. Тэтгэлгийн батламжийг Эрдмийн зөвлөлийн хуралдаан дээр суралцагчид эрдмийн зөвлөлийн дарга гардуулна.
- 3.9. Тэтгэлгийг жилд нэг удаа, 10 хүртэл суралцагчид давхардуулахгүйгээр олгоно.
- 3.10. Тэтгэлгийн хэмжээ тухайн хичээлийн жилийн МУИС-ийн бакалаврын түвшний сургалтын төлбөрийн дундажийн 60 хувиас хэтрэхгүй байна.

\*\*\*\*\*

**ДОКТОРЫН СУРГАЛТАНД СУРАЛЦАЖ БУЙ МУИС-ИЙН БАГШИД ТЭТГЭЛЭГ  
ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Тэтгэлгийн зориулалт**

- 1.1. “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын 3.3-р заалтыг хэрэгжүүлэх, МУИС-д үндсэн багшаар ажиллаж, тус сургуулийн докторын сургалтанд амжилттай суралцаж буй багшид төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр энэхүү тэтгэлгийг олгоно.
- 1.2. Тэтгэлгийг докторын сургалтанд элсэж, суралцвал зохих хугацаандаа тасралтгүй суралцаж, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийг судалж, судалгаа шинжилгээний ажилд идэвхитэй оролцож, диссертацийн судалгаагаа хийж буй суралцагчид нэг удаа олгоно.
- 1.3. Тэтгэлгийг сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр, шууд бусаар олгоно. Энэ журам гарахаас өмнө төлөгдсөн сургалтын төлбөрийг нөхөн хөнгөлөхгүй.

**Хоёр. Тэтгэлэгт нэр дэвшүүлэх, шалгаруулах**

- 2.1. Дараах болзлыг хангасан суралцагч энэхүү тэтгэлэгт нэр дэвших боломжтой. Үүнд:
  - Докторын сургалтанд элсэн 3-аас доошгүй улирал, 6 жилээс илүүгүй хугацаагаар суралцаж байгаа МУИС-ийн үндсэн багш
  - Суралцагч судалбал зохих мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийг судалж багц цагаа бүрэн биелүүлсэн байх
  - Суралцагч мэргэжлийн судалгааны семинарт тогтмол оролцож, диссертацийн судалгаагаа идэвхитэй хийдэг байх
- 2.2. Тэтгэлэгт тухайн суралцагчийн судалгааны ажлын удирдагч профессор багш нэр дэвшүүлнэ.
- 2.3. Нэр дэвшигчдийг тэтгэлэгт хамруулах асуудлыг мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган, шаардлага хангасан тохиолдолд холбогдох бичиг баримтыг хурлын тэмдэглэл, шийдвэрийн хамт Сургалтын нэгдсэн албанд хүргүүлнэ.
- 2.4. Тэтгэлэг олгох асуудлыг МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

**Гурав. Тэтгэлгийн хэмжээ**

- 3.11. Тэтгэлгийг нэг удаа, суралцагчид давхардуулахгүйгээр олгоно.
- 3.12. Тэтгэлгийн хэмжээ докторын түвшний сургалтын эрдэм шинжилгээний ажлын 18 багц цаг болон диссертацийн судалгааны 12 багц цагийн төлбөрөөс хэтрэхгүй буюу докторын сургалтын нийт төлбөрийн 50 хувиас илүүгүй байна.

\*\*\*\*\*

**Ц.ДАМДИНСҮРЭН, Ш.ЛУВСАНВАНДАН, Б.РИНЧЕН НАРЫН  
НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ**

**Нэг. Ерөнхий үндэслэл**

- 1.1. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1992 оны 2-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нэрт монгол судлаач Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан, Б.Ринчен нарын нэрэмжит тэтгэлэг олгоно.
- 1.2. Тэтгэлэгийн зорилго нь монгол судлалын чиглэлээр ажилладаг гадаадын залуу судлаачдыг ахисан түвшний сургалтанд хамруулж, мэргэшихэд нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүнд:
  - Ц.Дамдинсүрэнгийн нэрэмжит тэтгэлэг – Монголын утга зохиол, түүх
  - Ш.Лувсанвандангийн нэрэмжит тэтгэлэг – Монгол хэл бичиг, эх бичиг судлал
  - Б.Ринчений нэрэмжит тэтгэлэг – Утга соёл, угсаатны зүй, хүн судлал
- 1.3. Нэрэмжит тэтгэлэгийг жилд тус бүр нэг хүнд олгоно.
- 1.4. Суралцагч сургалтын хугацаандаа МУИС-ийн дүрэм, бусад холбогдох журам, зааврыг мөрдөх үүрэгтэй.

**Хоёр. Нэрэмжит тэтгэлэгт хамруулах болзол**

- 2.1. Монгол судлалын чиглэлээр докторантурт суралцаж байгаа болон докторын дараах судалгааны ажил хийх сонирхолтой 40 хүртэлх насны судлаач байх.
- 2.2. Суралцагч нь жил бүрийн 01-р сарын 15 эсвэл 09-р сарын 01-нээс 3-6 сарын хугацаагаар МУИС-д ирж, тодорхой хөтөлбөрийн дагуу ахисан түвшний сургалтанд хамрагдаж, судалгааны ажил хийнэ.
- 2.3. Нэрэмжит тэтгэлэг авахыг хүсэгч нь доорх материалыг бүрдүүлж, сургалтад хамрагдахаас 3 сарын өмнө МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнд ирүүлнэ. Үүнд:
  - Боловсрол, ажлын туршлагыг илтгэх биеийн байцаалт (CV)
  - Бүтээлийн жагсаалт
  - Суралцах зорилго, судлах зүйлийн хамрах хүрээ
  - Онцлох хүсэлт: аль тэнхимд хэний удирдлагаар сурах, нийслэлээс өөр газар явах шаардлагатай эсэх
  - Эрүүл мэндийн үзлэгийн бичиг
- 2.4. Тэтгэлэгт хөтөлбөрт нэрээ дэвшүүлэхэд бүртгэлийн хураамж 80 ам. доллар байна.

**Гурав. Тэтгэлэг олгох, шалгаруулах**

- 3.1. Тэтгэлэгт шалгарсан судлаачийн ажилд зөвлөх үүрэгтэй мэргэжлийн эрдэмтнийг зөвлөх профессороор томилж ажиллуулна.
- 3.2. Нэрэмжит тэтгэлэгт хамрагдах болзол хангасан судлаачид дараах тэтгэлэгийг олгоно. Үүнд:
  - Оюутны байранд амьдрах нөхцлөөр хангах

- Боловсролын зэргээс хамааруулж сар бүр 700.000 төгрөгийн тэтгэлэг олгох
  - Орон нутагт богино хугацаагаар судалгааны материал цуглуулах ажлаар явахад нэг удаа 300.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх
- 3.3. Тэтгэлгийн шалгаруулалтыг энэ журмын 6-р бүлэгт заасны дагуу мэргэжлийн багш нарыг оролцуулан байгуулсан ажлын хэсэг зохион байгуулна.
- 3.4. Суралцагч суралцах хугацаандаа судалгааны семинарт идэвхтэй оролцож илтгэл тавих, судалгааны ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлэх үүрэг хүлээнэ.
- 3.5. Тэтгэлэгээр суралцагч сургалт дуусахаас өмнө буюу сүүлчийн сарын тэтгэлгийг олгохоос өмнө судалгааныхаа ажлын тайланг мэргэжлийн тэнхимийн хурлаар хэлэлцүүлж, Сургалтын нэгдсэн албанд ирүүлнэ.

\*\*\*\*\*